

**“Эрдэнэс-Тавантолгой ХК”**

Огноо: .....

**АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЛИЙН САМБАР  
НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ  
АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр:                   **Аюулгүй ажиллагааны мэдээллийн самбар  
нийлүүлэгчийг сонгох**  
Харьцуулалт/  
гэрээний дугаар:               **ЭТТ/201901249**

## **Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

**“Эрдэнэс Тавантолгой” ХК** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Аюулгүй ажиллагааны мэдээллийн самбар** нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн саналыг 2019 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 10 цаг 30 минутаас өмнө Төрийн өмчийн бодлого зохицуулалтын цахим систем болох [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 11 цаг 00 минутад “Эрдэнэс Тавантолгой” ХК, Жигжиджав-8, Финанс төв, 1 давхрын хурлын өрөөнд нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8,  
Финанс төв 5 давхар, 503 тоот, Улаанбаатар-15160  
Утас: 75055555-562, Факс: 70118464,  
Холбоо барих ажилтан: Ж.Даваажаргал**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |   |
|---|---|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | <b>1.1.</b> Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.  |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | <b>2.1.</b> Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br><b>2.2.</b> Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.<br><b>2.3.</b> Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | <b>3.1.</b> Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]  |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | <b>4.1.</b> Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.   |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | <b>5.1.</b> Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br><b>5.2.</b> Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.   |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | <b>6.1.</b> Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **TШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь запруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТОӨЗ- НЫ ХОЛБОГДО Х ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> <li>➤ Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</li> <li>➤ Үнийн санал</li> <li>➤ Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт /Тендер зарласан өдрөөс хойших байдлаар/</li> <li>➤ Татварын албаны цахим тодорхойлолт /Тендер зарласан өдрөөс хойших байдлаар, тендер нээсэн үеийн байдлаар өр төлбөргүй байх/</li> <li>➤ 2018 онд ижил төстэй ажил гүйцэтгэж байсан 2-оос доошгүй гэрээний хуулбар гэрээ дүгнэсэн актын хуулбар тус бүрийг нотариатоор батлуулан ирүүлэх.</li> <li>➤ Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтсан техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасан ажлыг гүйцэтгэх баталгааг бичгээр ирүүлнэ.</li> <li>➤ Өмнө нь хийж гүйцэтгэж байсан самбарын зураг ирүүлэх</li> </ul>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:          Тендерийг 2019 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 10 цаг 30 минутаас өмнө Төрийн өмчийн бодлого зохицуулалтын цахим системд ирүүлэх</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:          Нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 11 цаг 00 минутад “Эрдэнэс-Тавантолгой” ХК, Жигжиджав-8, Финанс төв, 5 давхрын хурлын өрөөнд нээнэ.</p>
ТОӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>багцгүй</i>

**Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

**1. Барааны тодорхойлолт:**

<b>№</b>	<b>Техникийн тодорхойлолт</b>	<b>Зураг</b>
1	<p>Лед самбар:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ 400x40 см хэмжээтэй</li> <li>➢ Дотор зориулалтын Р3,75 нягтаршилтай 3 өнгийн лед гэрлээр хийгдсэн байх</li> <li>➢ Статик, урсдаг, слайд үйлдлийн тохиргоотой.</li> <li>➢ USB оролтоор өгөгдөл дамжуулах боломжтой.</li> </ul>	
2	<p>Мэдээллийн самбар</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ 600x300 см хэмжээтэй</li> <li>➢ карказ болон рам төмөр нь 50x50 см булан төмрөөр зангидах хийсэн</li> <li>➢ 1,2мм зузаантай лист төмрөөр хийсэн</li> <li>➢ 2 талдаа нүүртэй.</li> <li>➢ 200мм диамертэй 6 метрээс доошгүй өндөртэй 2 зэрэгцээ төмөр хөлтэй</li> <li>➢ Хулдаасан хэвлэл тогтоох 15x15 булан төмрийг 2м-р таслаж бэлтгэсэн байх</li> </ul>	
3	<p>Анхааруулах самбар:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ 120x200 см харьцаатай.</li> <li>➢ Зэвэрдэггүй төмөр материал дээр сайн чанарын гэрэлтдэг хуулгаар хийх.</li> <li>➢ Самбарын гаднах хүрээ нь төмөр хавтангаас дотогш 3мм зай үлдээсэн байна.</li> <li>➢ Үсэг болон зурагны хэмжээ, фонд, пропорцыг алдагдуулахгүй.</li> <li>➢ Заах тэмдэгний дэвсгэр хөх өнгө ижилхэн байна.</li> <li>➢ Арын дэвсгэр өнгө зурган дээрхээс зөрөхгүй байна.</li> <li>➢ Өгөгдсөн зураг дүслэлд өөрчлөлт оруулахгүй.</li> </ul>	

	<ul style="list-style-type: none"> <li>➤ Самбарны хөл 2,5м урттай, 60мм диаметртэй, зэвэрдэггүй цагаан труба байх ба самбартай бэхлээгүй тусад нь ирүүлэх.</li> <li>➤ Самбарыг нугларахаас хамгаалж дээд, доод хэсэгт 2ширхэг 180 см-ийн урттай хөндлөвч хийх ба хөндлөвчин дээр 2 хөлийг бэхлэх хомуттай байна. Доорх зургаас харна уу.</li> </ul> 									
4	<p>Уурхайн аюулгүй ажиллагааны самбар:</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ 200x100 см харьцаатай.</li> <li>➤ Төмөр материал дээр сайн чанарын гэрэлтдэг хуулгаар хийх.</li> <li>➤ Самбарын гаднах хүрээ нь төмөр хавтангаас дотогш 3мм зай үлдээсэн байна.</li> <li>➤ Үсэг болон зурагны хэмжээ, фонд, пропорцыг алдагдуулахгүй.</li> <li>➤ Заах тэмдэгний дэвсгэр хөх өнгө ижилхэн байна.</li> <li>➤ Арын дэвсгэр өнгө зурган дээрхээс зөрөхгүй байна.</li> <li>➤ Өгөгдсөн зураг дүслэлд өөрчлөлт оруулахгүй.</li> <li>➤ Самбарны хөл 3м урттай, 60мм диаметртэй, зэвэрдэггүй цагаан труба байх ба самбартай бэхлээгүй тусад нь ирүүлэх.</li> <li>➤ Самбарыг нугларахаас хамгаалж дээд, доод хэсэгт 2ширхэг 80см-ийн урттай хөндлөвч хийх ба хөндлөвчин дээр 2 хөлийг бэхлэх хомуттай байна. Доорх зургаас харна уу.</li> </ul>	<p><b>УУРХАЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА</b></p> <p>Бүх зонийн эхийн оффист бүртгүүлийн зөвшөөрөлжилсэнэйн дараа уурхай бүс руу настарч болно. Тамдаг замдлагын болон дурмыг дагамж мөрдэвнүү. Наг бүрийг хамгаалах хэрэгслийг байнга ижимж наах шандалдигийтэй.</p> <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <tr> <td style="text-align: center; padding: 5px;">  <b>ЗӨВШӨӨРӨЛГҮЙ ХҮН ОРОХЫГ ХАТУУ ХОРИГЛОНО.</b> </td> </tr> <tr> <td style="text-align: center; padding: 5px;">  <b>ХАМГААЛАЛТЫН ДУУЛГА ӨМС.</b> </td> </tr> <tr> <td style="text-align: center; padding: 5px;">  <b>ХАМГААЛАЛТЫН ГУТАЛ ӨМС.</b> </td> </tr> <tr> <td style="text-align: center; padding: 5px;">  <b>ТОД ХАРАГДАХУЙЦАЖЛЫН ХУВЦАС ӨМС.</b> </td> </tr> <tr> <td style="text-align: center; padding: 5px;">  <b>ХАМГААЛАЛТЫН НҮДНИЙ ШИЛ ЗҮҮ.</b> </td> </tr> <tr> <td style="text-align: center; padding: 5px;">  <b>ТАМХИ ТАТАХЫГ ХАТУУ ХОРИГЛОНО.</b> </td> </tr> <tr> <td style="text-align: center; padding: 5px;"> <b>ХАМГААЛАЛТЫН ГУТАЛ, ДУУЛГАГҮЙ БОЛ ТА ЭНД АЖИЛЛАХ ЭРХГҮЙ!</b> </td> </tr> <tr> <td style="text-align: center; padding: 5px;">  <b>ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН НЭГЖ УУРХАЙН ОФИСТ БАЙРЛАЖ БАЙНА.</b> </td> </tr> </table>	 <b>ЗӨВШӨӨРӨЛГҮЙ ХҮН ОРОХЫГ ХАТУУ ХОРИГЛОНО.</b>	 <b>ХАМГААЛАЛТЫН ДУУЛГА ӨМС.</b>	 <b>ХАМГААЛАЛТЫН ГУТАЛ ӨМС.</b>	 <b>ТОД ХАРАГДАХУЙЦАЖЛЫН ХУВЦАС ӨМС.</b>	 <b>ХАМГААЛАЛТЫН НҮДНИЙ ШИЛ ЗҮҮ.</b>	 <b>ТАМХИ ТАТАХЫГ ХАТУУ ХОРИГЛОНО.</b>	<b>ХАМГААЛАЛТЫН ГУТАЛ, ДУУЛГАГҮЙ БОЛ ТА ЭНД АЖИЛЛАХ ЭРХГҮЙ!</b>	 <b>ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН НЭГЖ УУРХАЙН ОФИСТ БАЙРЛАЖ БАЙНА.</b>
 <b>ЗӨВШӨӨРӨЛГҮЙ ХҮН ОРОХЫГ ХАТУУ ХОРИГЛОНО.</b>										
 <b>ХАМГААЛАЛТЫН ДУУЛГА ӨМС.</b>										
 <b>ХАМГААЛАЛТЫН ГУТАЛ ӨМС.</b>										
 <b>ТОД ХАРАГДАХУЙЦАЖЛЫН ХУВЦАС ӨМС.</b>										
 <b>ХАМГААЛАЛТЫН НҮДНИЙ ШИЛ ЗҮҮ.</b>										
 <b>ТАМХИ ТАТАХЫГ ХАТУУ ХОРИГЛОНО.</b>										
<b>ХАМГААЛАЛТЫН ГУТАЛ, ДУУЛГАГҮЙ БОЛ ТА ЭНД АЖИЛЛАХ ЭРХГҮЙ!</b>										
 <b>ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН НЭГЖ УУРХАЙН ОФИСТ БАЙРЛАЖ БАЙНА.</b>										

		
5	<p>Цанхийн нүүрсний уурхайн самбар:</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ 200x300 см харьцаатай.</li> <li>➤ Төмөр материал дээр сайн чанарын гэрэлтдэг хуулгаар хийх.</li> <li>➤ Самбарын гаднах хүрээ нь төмөр хавтангаас дотогш 3мм зайд үлдээсэн байна.</li> <li>➤ Үсэг болон зурагны хэмжээ, фонд, пропорцыг алдагдуулахгүй.</li> <li>➤ Заах тэмдэгний дэвсгэр хөх өнгө ижилхэн байна.</li> <li>➤ Арын дэвсгэр өнгө зурган дээрхээс зөрөхгүй байна.</li> <li>➤ Өгөгдсөн зураг дүслэлд өөрчлөлт оруулахгүй.</li> <li>➤ Самбарны хөл 3м урттай, 60мм диаметртэй, зэвэрдэггүй цагаан труба байх ба самбартай бэхлээгүй тусад нь ирүүлэх.</li> <li>➤ Самбарыг нугларахаас хамгаалж эргэн тойрон 2.5мм-ийн угольникоор рам зангидааж, рамны дотор талаар дээд, доод хэсэгт 2 ширхэг 280см-ийн урттай хөндлөвч хийх ба 2 хөлийг рам болон хөндлөвчинд бэхлэх хомуттай байна.</li> </ul>	

6	<p>Улаан бүс:</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ 100x160 см харьцаатай.</li> <li>➤ Төмөр материал дээр сайн чанарын гэрэлтдэг хуулгаар хийх.</li> <li>➤ Самбарын гаднах хүрээ нь төмөр хавтангаас дотогш 3мм зай үлдээсэн байна.</li> <li>➤ Үсэг болон зурагны хэмжээ, фонд, пропорцыг алдагдуулахгүй.</li> <li>➤ Арын дэвсгэр өнгө зурган дээрхээс зөрөхгүй байна.</li> <li>➤ Өгөгдсөн зураг дүслэлд өөрчлөлт оруулахгүй.</li> <li>➤ Самбарны хөл 2.5м урттай, 60мм диаметртэй, зэвэрдэггүй цагаан труба байх ба самбартай бэхлээгүй тусад нь ирүүлэх.</li> <li>➤ Самбарыг нугларахаас хамгаалж дээд, доод хэсэгт 2ш хөндлөвч хийх ба хөндлөвчин дээр 2 хөлийг бэхлэх хомуттай байна. Доорх зургаас харна уу.</li> </ul> 	
7	<p>Шар бүс:</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ 100x120 см харьцаатай.</li> <li>➤ Төмөр материал дээр сайн чанарын гэрэлтдэг хуулгаар хийх.</li> <li>➤ Самбарын гаднах хүрээ нь төмөр хавтангаас дотогш 3мм зай үлдээсэн байна.</li> <li>➤ Үсэг болон зурагны хэмжээ, фонд, пропорцыг алдагдуулахгүй.</li> <li>➤ Арын дэвсгэр өнгө зурган дээрхээс зөрөхгүй байна.</li> <li>➤ Өгөгдсөн зураг дүслэлд өөрчлөлт оруулахгүй.</li> </ul>	

	<ul style="list-style-type: none"> <li>➤ Самбарны хөл 2.5м урттай, 60мм диаметртэй, зэвэрдэггүй цагаан труба байх ба самбартай бэхлээгүй тусад нь ирүүлэх.</li> <li>➤ Самбарыг нугларахаас хамгаалж дээд, доод хэсэгт 2ш хөндлөвч хийх ба хөндлөвчин дээр 2 хөлийг бэхлэх хомуттай байна. Доорх зургаас харна уу.</li> </ul> 	
8	<p>Цугларах цэг:</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ 60x60 см харьцаатай.</li> <li>➤ Төмөр материал дээр сайн чанарын гэрэлтдэг хуулгаар хийх.</li> <li>➤ Самбарын гаднах хүрээ нь төмөр хавтангаас дотогш 3мм зай үлдээсэн байна.</li> <li>➤ Үсэг болон зурагны хэмжээ, фонд, пропорцыг алдагдуулахгүй.</li> <li>➤ Арын дэвсгэр өнгө зурган дээрхээс зөрөхгүй байна.</li> <li>➤ Самбарны хөл 2.5м урттай, 60мм диаметртэй, зэвэрдэггүй цагаан труба байх ба самбартай бэхлээгүй тусад нь ирүүлэх.</li> <li>➤ Хөлийг бэхлэх хомуттай.</li> <li>➤ Хөлийг тусад нь ирүүлэх. зургаас харна уу.</li> </ul> 	

9	<p><b>Хулдаасан хэвлэл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>➢ 600x300 см харьцаатай.</li> <li>➢ Гадаа хэрэглэдэг сайн чанарын хулдаасан дээр хэвлэх.</li> <li>➢ Өнгөний нягтаршил сайн.</li> <li>➢ 4 талдаа татаж уях гогцоо бүхий татуурга уятай байх.</li> <li>➢ 2 талд хийнэ.</li> </ul>	
---	--	--

2. **Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл [Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.] гэж бичнэ
3. **Баглаа, боодол:** [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг тодорхой заана. Баглаа боодлын нөхцөлийг цаг уур, давс, барааны жин, ачих буулгах хэрэгсэл, далайгаар тээвэрлэх тохиолдолд хөлөг онгоцны тавцан дээр, эсхүл доор тээвэрлэх зэргийг харгалзаж тодорхойлно. Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.]
4. **Бараа хүргэх газар:** [Эрдэнэс Тавантолгой ХК-ын агуулах]
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

#### **БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгч ийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
	Нийлүүлэх бараа			ЭТТ Улаанбаа тар дахь агуулах	Гэрээ байгуулснаас хойш 14 хоног	Гэрээ байгуулснаас хойш 40 хоног	

## Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

### 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

<b>1. Шалгах болон турших</b>	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
<b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b>	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
<b>3. Оюуны өмчийн эрх</b>	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
<b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
<b>5. Баталгаат засварын хугацаа</b>	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[тоо]</b> жил байна.
<b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
<b>7. Төлбөр</b>	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.
<b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
<b>9. Алданги оногдуулах</b>	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
<b>10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах</b>	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
<b>11. Маргааныг шийдвэрлэх</b>	11.1.	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>   | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]  |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b>   | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;<br>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;<br>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;<br>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;<br>5) барааны гарал үүслийн гэрчилгээ. |
| <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |  |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>  | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.<br>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]  |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br><br>Урьдчилгаа төлбөр олгохгүй бараа нийлүүлсний дараа олгоно.  |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup></b>  | 9.1. Алданги оногдуулах хувь: <b>[moο]</b><br><br>Алдангийн нийт дүн: <b>[moο]</b>   |

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дунгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

## Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>2</sup>

БАТЛАВ.

### ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

### НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нэгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]